



2019 оны 04 дүгээр сарын 05
№14/1067/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүгчийн албан тушаалд
шилжүүлэн томилох тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Үндэсний хөтөлбөр
батлах тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт**

**Эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хуулийн
зарим заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн
эсэх маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

101.	Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай	Дугаар 30	470
102.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 36	470
103.	Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай	Дугаар 43	471
104.	Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай	Дугаар 44	471
105.	Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай	Дугаар 45	472
106.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 49	472
107.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 50	473
108.	А.Ганбатыг албан тушаалд томилох тухай	Дугаар 51	473
109.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 53	474

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

110.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 400	474
111.	Журам батлах тухай	Дугаар 1	488

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

112.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 01	493
------	--	-----------	-----



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Эрдэнийн Одхүүг Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Дашдоржийн Азжаргалыг Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжин томилогдох болсонтой холбогдуулан Эрдэнийн Одхүүг Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дашдоржийн Азжаргалыг Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан шүүгч Намдагийн Нямсүрэн Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Төмөрбаатарын Бадрахыг Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжин томилогдох болсонтой холбогдуулан Төмөрбаатарын Бадрахыг Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Пандийн Долормаад эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тул эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Содномдаржаагийн Батжаргалд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа тул эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Исланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Санжийн Баярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Исланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нархүүгийн Тулгыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Ирланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Санжийн Баярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Ирланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нархүүгийн Тулгыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

А.Ганбатыг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Аюушийн Ганбатыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 03 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн шүүгч Лханаажавын Оюунчимэгийг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Дансрангийн Бавууг Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 400

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Н.Цэрэнбат)-д даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улс болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийг

сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
(Н.Цэрэнбат) болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ**

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2018 оны 400 дугаар
тогтоолын хавсралт

**ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны гүйцэтгэлээр 3.7 их наяд төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдхүүний үйлдвэрлэлд 10.6 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 87 хувь, нийт экспортын орлогод 8.4 хувийг тус тус эзэлж, нийт ажиллах хүчний 30 хувь тус салбарт ажиллаж байна. Гэвч дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, ган, зудын давтамж, газрын доройтол, бэлчээрийн хомсдол, даац хэтрэлт, малын тооны хэт өсөлт зэрэг нь нөөцийн хязгаарлагдмал байдлыг үүсгэж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг явуулах арга барилд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох эрэлт хэрэгцээ, шаардлага өдрөөс өдөрт нэмэгдэх боллоо.

Манай улс 1950-иад оноос эхлэн мах, сүүний, хосолмол ашиг шимт үүлдрийн үхэр, сүүний ямаа, мах, ноосны хонь болон гахай, шувууг гадаад орноос авчирч, өсгөн үржүүлж байгаа ч мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрчимжүүлэлтийн талаарх ойлголт харьцангуй өөр өөр байна. Тухайн чиглэлийн мал, амьтны онцлогоос хамаарч энэ төрлийн аж ахуйн хөгжил, үйлдвэрлэл, технологи, шийдвэрлэх асуудлууд мөн харилцан адилгүй түвшинд байгаа болно.

Манай улсад эрчимжсэн чиглэлийн 1963 өрх, аж ахуйн нэгжид цэвэр үүлдрийн болон эрлийз 102,4 мянган үхэр, 1528 өрх, аж ахуйн нэгжид 355,0 мянган хонь, ямаа, 949 өрх, аж ахуйн нэгжид 28,4 мянган гахай, 1197 өрх, аж ахуйн нэгжид 798,4 мянган шувуу, 457 өрх, аж ахуйн нэгжид 11,5 мянган бүл зөгийг тус тус өсгөн үржүүлж, төвлөрсөн хүн амын хүнсний хэрэгцээнд түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. Гэвч нэг малаас авах ашиг шимийн хэмжээ улсын хэмжээний дунджаар хангалтгүй байна.



Ихэнх улс орнууд сүүний чиглэлийн нэг үнээнээс жилд дунджаар 5500-9500 литр сүү сааж, махны чиглэлийн 12-18 сарын настай өсвөр үхрээс дунджаар 320 кг, хониноос дунджаар 35 кг мах авдаг бол манай улсын жилийн дунджаар монгол үхрээс 800 литр, эрлийз үхрээс 2200 литр сүү, үхрээс 180 кг, хониноос 18 кг мах авч байна. Иргэд, аж ахуйн нэгжийн хувьд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх сонирхол их байна. Гэвч олон талт хүчин зүйлсийн нөлөөллөөр дотоодын эрэлт хэрэгцээ, хэрэглэгчийн шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна.

Манай улсын малын тоо 66,2 сая толгойд хүрсэн ч дотооддоо үйлдвэрлэх боломжтой мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг импортоор авч их хэмжээний валют зарцуулж байна. Тухайлбал, гаалийн 2016 оны мэдээгээр манай улс нь малын гаралтай 18 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг 34,1 сая ам.доллараар, 5 нэр төрлийн малын тэжээлийг 7,0 сая ам.доллараар, нийт 41,1 сая ам.долларын буюу 98,6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг импортоор авсан байна. Энэхүү үзүүлэлт 2017 оны гаалийн мэдээгээр 63,9 сая ам.доллар буюу 159,8 тэрбум төгрөгт хүрч, 1,6 дахин өсчээ.

Эрчимжсэн аж ахуйн мал, амьтны өнөөгийн тоо, дундаж хэрэглээнд суурилан тооцоход улсын хэмжээнд жилд нийт 187,4 мянган тонн тэжээл шаардлагатай байна. Үйлдвэрлэж байгаа малын тэжээлийг зөвхөн эрчимжсэн аж ахуйд ашиглана гэж тооцоход тэжээл хангамж 53,4 хувь байна. Ялангуяа гахай, шувуунд зориулсан дотоодын тэжээлийн үнэ өндөр, зарим нэмэлт түүхий эдийн олдоц муу байгаатай уялдан энэ чиглэлийн аж ахуй эрхлэгчид тэжээлийн үндсэн болон нэмэгдэл түүхий эдийг зонхилон импортоор авч байна.

Дээрх төлөв байдлын тоймоос дүгнэхэд мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг бага, нэг малаас авах түүхий эд, бүтээгдэхүүний гарц доогуур, малын тэжээлийн хангамж, хүртээмж туйлын хангалтгүй, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого, ашиг бага, алдагдалтай байгаа учраас ихэнх аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсооход хүрч байна. Тухайлбал, 2013 онд гахайн тоо 51,9 мянган толгой байсан бол 2017 онд 23,5 мянган толгойгоор буурчээ.

Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тодорхой түвшинд эрчимжүүлж, бүтээмж, үр ашгийг нь нэмэгдүүлэн, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортыг үе шаттай бууруулах, дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэхийн тулд хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын санал санаачилгыг дэмжих, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд төрийн бодлогоор дорвитой дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.



Иймд мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн, тэжээлийг импортлоход зарцуулж байгаа их хэмжээний валютын урсгалыг дотоодын үйлдвэрлэлд чиглүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл, эрчимжүүлэлтийг дэмжих, иргэдийн амьжиргаа, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

3.1. эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх;

3.2. мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;

3.3. гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах;

3.4. эрчимжсэн аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж, үр ашгийг нь нэмэгдүүлэх;

3.5. боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах;

3.6. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачилга, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих;



3.7. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхжуулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. “Эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг чиглэл, цар хүрээ, зорилтот зах зээл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн түвшинтэй нь уялдуулан төрөлжүүлэн ангилах, бүсчлэл тогтоох, баталгаажуулах;

4.1.2. сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйг нийслэл орчмын, аймгийн төвийн, тариалангийн бүсийн гэсэн гурван чиглэл, үйл ажиллагааны түвшнээр ангилж, кластер, цогцолборын зохион байгуулалтад оруулах, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцооны шинэчлэлийг дэмжих, хөгжүүлэх;

4.1.3. махны чиглэлийн үхэр, хонь үржүүлэх, бордох чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид, мэргэжлийн холбоод, боловсруулах үйлдвэрийн хамтын ажиллагааг гарал үүслийн баталгаажуулалт, хяналтад суурилсан мал, мах бэлтгэн нийлүүлэх сүлжээнд шилжүүлж, тогтолцооны шинэчлэлийг дэмжих, хөгжүүлэх;

4.1.4. гахайн аж ахуйн үйлдвэрлэлийг томоохон (500-аас дээш толгой), дунд (150-500 хүртэл толгой), өрхийн (150-аас доош толгой) гэсэн гурван түвшнээр ангилж, цэвэр үүлдрийн үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчээр хангах үржлийн аж ахуйн үйлчилгээ, тэжээл нийлүүлэлтийн сүлжээ бүхий кластерын зохион байгуулалтыг мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх;

4.1.5. зөгийн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүсчлэл, хамтын ажиллагааны цар хүрээгээр кластерын зохион байгуулалтад оруулж, бодлогоор дэмжиж, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх;

4.1.6. мал аж ахуйн бусад чиглэлийн эрчимжсэн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулах асуудлыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжин мэргэжил, арга зүй, технологийн зөвлөгөө өгөх;

4.1.7. цэвэр үүлдрийн үржлийн мал, зориулалтын техник, тоног төхөөрөмж, тэжээл нийлүүлэх, бүтээгдэхүүнийг үйлдвэрт хүргэх

зэрэг ложистикийн төрөлжсөн үйлчилгээг хөгжүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;

4.1.8. эрчимжсэн аж ахуйд сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт хээлтэгч, эх сүргийг нийлүүлэх чиглэлээр дагнасан үржлийн аж ахуй эрхлэгчид олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.9. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид бэлчээр, хадлангийн газар, таримал тэжээл тариалах тариалангийн талбайг гэрээгээр ашиглуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.

4.2. “Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. шингэн сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн хөлдүү мах, өндөг, гахай, шувууны мах, өөх, зөгийн балны импортыг үе шаттайгаар бууруулах, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн холбоодтой хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх;

4.2.2. сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл, технологийн түвшинг сайжруулан, гойд ашиг шимт үхрийн тоог нэмэгдүүлэх, зохиомол хээлтүүлгийн цар хүрээг тэлэх арга хэмжээг хэрэгжүүлж, дотоодын шингэн сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөх, импортын шингэн болон шар сүүг бүрэн халж, цөцгийн тос, аарц, тараг зэрэг сүүн бүтээгдэхүүний импортыг 30 хүртэл хувиар бууруулах;

4.2.3. махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн технологийн эрчимжүүлэлтийг дэмжиж, махны экспортын бодлогод нийцүүлэн мал бордох үр ашигтай аргачлал, технологийг нэвтрүүлж, мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бүрэн халж, махны экспортыг 30 хүртэл хувиар нэмэгдүүлэх;

4.2.4. шувууны аж ахуйн технологийн түвшинг сайжруулах, эрчимжүүлэх, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхэй нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндгийг 90-ээс доошгүй хувь, импортын шувууны махыг 30 хүртэл хувиар тус тус бууруулах;

4.2.5. том, дунд түвшний гахайн аж ахуйг чадавхжуулж, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, үржлийн өсвөр гахай, бүрэн найрлагат



тэжээлээр хангах кластерын тогтолцоог хөгжүүлэн, гахайн мах, өөхний импортыг 15 хувиар бууруулах;

4.2.6. зөгийн аж ахуйн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологийн түвшин, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэж, зорилтот зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж, импортын зөгийн балыг 70 хүртэл хувиар бууруулах;

4.2.7. мал, амьтны гаралтай импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах тарифын болон тарифын бус зохицуулалтыг тухай бүр хэрэгжүүлэх;

4.2.8. шувууны аж ахуйд сүрэг сэлбэх үр тогтсон өндөг, үржлийн амьд шувуу, дэгдээхэйг импортоор оруулахад татварын хөнгөлөлт үзүүлэх, импортын өндгөнд 5 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд улирлын хязгаарлалт тогтоох асуудлыг судалж, шийдвэрлэх;

4.2.9. мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн эм, гоо сайхны бүтээгдэхүүний түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, экспортлох чиглэлийн судалгааг явуулах, эрдэм шинжилгээний болон үйл ажиллагааны тухайлсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.3. “Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн 3600 хээлтэй гунж, хосолмол ашиг шимт 2200 хээлтэй гунжийг импортлон нутагшуулах, тэдгээрийн үр төлд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоодын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж, сүүний үхрийн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлэх;

4.3.2. махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйд махны хэмжээ, гарцыг нэмэгдүүлэх үржил селекцийн ажлыг явуулж, гадаадаас авчирсан махны чиглэлийн гойд ашиг шимт үхэр, хонины тэжээллэг, арчилгаа, маллагааны технологийг мөрдүүлж, удам зүйн үнэлгээгээр шалгарсан үржлийн өсвөр бухыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хамрах хүрээг тэлэх, бүсчлэлийн бодлогоор махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;

4.3.3. өндөгний болон махны чиглэлийн тухайлсан үүлдрийн үржлийн 20 мянган өндгийг импортлох, хоногийн настай дэгдээхэйг бойжуулж, аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээнд нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгох, өндөгний чанар, баталгаажуулалт, импортын өндөгний хяналтыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллага, холбоод хамтын ажиллагааг нягтруулж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий шувууны аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;

4.3.4. цэвэр үүлдрийн 1000 мэгж, 50 бодонг Европын бүсээс импортлон гахайн аж ахуйд үржлийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлэн, өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээг хангах, зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлэх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, холбоод хамтран хэрэгжүүлэхийг дэмжиж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий гахайн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;

4.3.5. өндөр ашиг шимт, баталгаажсан зөгийн үүлдрийн 2000 бүлийг импортлон нутагшуулах, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, зөгийн үржлийн ажлыг сайжруулах, чадавхжуулах арга хэмжээг мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр зөгийн аж ахуйн кластерыг хөгжүүлэх;

4.3.6. хот, суурингийн хүн амын хүнсний хэрэгцээнд эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, хүртээмж, хүнсний аюулгүй байдлын баталгааг сайжруулах үйл ажиллагаанд бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;

4.3.7. эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, гурилын үйлдвэрүүдийг түшиглэн бүс нутгийн хэмжээнд тэжээл үйлдвэрлэл, тэжээл хүргэлтийн үйлчилгээний ложистикийг хөгжүүлэх;

4.3.8. одоо байгаа малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо, байршил, хүчин чадлын ашиглалтын түвшинг тогтоож, тэжээлийн үндсэн түүхий эдийн нөөцийг бүрдүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, эрчимжсэн аж ахуйн хүчит тэжээлийн хангамжийг 30 хувиар нэмэгдүүлэх;

4.3.9. тариалангийн 100 мянга хүртэлх га талбайд тэжээлийн ургамал тариалж, эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг 50 хувиар нэмэгдүүлэх;



4.3.10. гахай, шувууны тэжээлийн орцын үндсэн болон бусад түүхий эд, шар буурцаг, наранцэцэгийн шахдас, төмрийн бэлдмэл, амин дэм, амин хүчлийн импортын татварыг бууруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

4.4. “Эрчимжсэн аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж, үр ашгийг нь нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. бүс нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн системд эрчимжсэн мал аж ахуйн кластерыг хөгжүүлэх;

4.4.2. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг явуулах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, үржлийн мал, амьтан, үржүүлгийн бүтээгдэхүүний импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварыг хөнгөлөх, чөлөөлөх асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.4.3. эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг багасгах, хадлан, тэжээлийн өртгийг бууруулах хүчин зүйлсийг судлан тогтоож, мал, амьтны төрөл тус бүрт зориулагдсан тэжээллэгийн үр ашигтай хувилбаруудыг туршилтаар гаргах;

4.4.4. дарш хийх, олон найрлагат хорголжин, багсармал тэжээл, макро, микро элементээр баяжуулсан эрдсийн шахмал, уурагжуулсан, витаминжүүлсэн тэжээл үйлдвэрлэлд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, мал, амьтны төрөл, ашиг шимийн чиглэл, түвшин, физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай өвс, тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлэх;

4.4.5. мах, махан бүтээгдэхүүн, өндөгний техникийн зохицуулалтыг боловсруулах, гахай, шувууны мах, өөхний стандартыг тогтоох, шинэчлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

4.4.6. эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бүс нутагт олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгох, үржүүлэг, технологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулах;

4.4.7. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд технологийн эрчимжүүлэлтийг нэмэгдүүлж, техник, технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийх үйл ажиллагаанд санхүүжилтийн шинэ арга барилыг нэвтрүүлж, техникийн хангамжийг 2017 оны түвшнээс 50 хүртэл хувиар нэмэгдүүлэх;

4.4.8. өндөр ашиг шимт малын үр, хөврөлийг малын генийн санд хадгалах, гүн хөлдөөсөн болон хүйс жолоодсон үрийг ашигласан зохиомол хээлтүүлгийн ажлын цар хүрээг тэлэх, хөврөл үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх;

4.4.9. эрчимжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд малын тэжээл тариалах, хадлан, тэжээл хураах, бүтээгдэхүүнийг хүргэх, анхан шатны боловсруулалт хийх техник дундын болон явуулын үйлчилгээ, зориулалтын тээврийн хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх;

4.4.10. гахай, тахианы эрчимжсэн аж ахуйд ашигладаг малын эмийг улсын бүртгэлийн жагсаалтад оруулах, мал эмнэлгийн үйлчилгээний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилтийн ялгавартай байдлыг арилгах;

4.4.11. мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг, шинжилгээ хийх, зохиомол хээлтүүлэг явуулах, малд үзлэг, ангилалт хийхэд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх;

4.4.12. гойд ашиг шимт үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа, эрчимжсэн мал аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, техник, технологийн үзэсгэлэнг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулах.

4.5. “Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. мал, амьтны сүргийн нөхөн үйлдвэрлэлийг мөчлөгийн үр ашигтай системд шилжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг үе шаттай бууруулах;

4.5.2. мал, амьтны төрөл, үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарцтай уялдуулан сүрэгт явуулах үржүүлгийн хөтөлбөрийг шинэчилж, сүргийн хээлтүүлэг, төллөлтийг технологийн дагуу удирдаж, аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;

4.5.3. зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний чанар, хүнсний сүлжээний аюулгүй байдлыг баталгаажуулах бүртгэлийн системийг мэргэжлийн байгууллага, холбоодын үйл ажиллагаанд суурилан кластер, цогцолбор тус бүрт хэрэгжүүлэх;

4.5.4. гахай, шувууны мах, өөх, өндөг, зөгийн балны импортыг үе шаттай бууруулах, газар зүйн заалт бүхий мах, зөгийн балны экспортыг нэмэгдүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;



4.5.5. боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, хангамжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлын баталгааг хангах хөшүүргийг урамшууллын системээр дамжуулж бий болгох, төлөвшүүлэх.

4.6. “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачилга, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.6.1. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын болон санхүүжилтийн шинэ эх үүсвэрт суурилсан урт хугацааны, хөнгөлттэй дэмжлэг, татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчинг сайжруулж, Мал хамгаалах сангийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх;

4.6.2. эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутагт газар тариалан, мал аж ахуйн хосолсон үйлдвэрлэл хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байр шинээр бий болгох санал, санаачилгыг хөрөнгө оруулалтын болон татварын бодлогоор дэмжих;

4.6.3. салбарын урт, дунд хугацааны бодлогын болон мал эмнэлгийн эрүүл бүсийн зорилтод нийцүүлэн махны чиглэлийн үхэр, хонины эрчимжүүлсэн үйлдвэрлэлийг тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэх;

4.6.4. Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, импортыг бууруулах үйл ажиллагаанд татварыг хөнгөвчлөх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.6.5. Дараахь чиглэлийн эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, бусад хуулийн этгээдэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх:

а/ бүс нутагт сүү, махны чиглэлийн үхэр, махноосны чиглэлийн хонины болон гахайн загвар аж ахуйн нэгжийг бий болгох;

б/ малын шүүст, ногоон тэжээлийн ургамал тариалж, эрчимжсэн аж ахуйд хөнгөлттэй нөхцөлөөр нийлүүлэх;

в/ бүрэн найрлагат тэжээл болон тэжээлийн нэмэгдэл, сайн чанарын шүүст, бүдүүн, тэжээл бэлтгэн эрчимжсэн аж ахуйд тогтмол нийлүүлэх;

г/ үржлийн сайн чанарын өсвөр бух, гунж бойжуулан сүүний болон махны чиглэлийн үхэр үржүүлэх аж ахуйн нэгжүүдийг хангах;

д/ үржлийн сайн чанарын өсвөр хуц, охин төлөг бойжуулан мах, нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэх аж ахуйн нэгжид нийлүүлэх;

е/ үржлийн өсвөр гахай, хоногийн настай дэгдээхэй бойжуулж гахай, шувууны аж ахуй эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийг хангах;

ж/ тэжээлийн нэг ба олон наст ургамлын үрийг дотооддоо үйлдвэрлэх, тэжээлийн ургамал тариалах, үрийн нөөц бий болгох;

з/ эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд “эргэлтийн механизм”-ыг нэвтрүүлэх бусад улс орны туршлагыг нутагшуулах, түгээн дэлгэрүүлэх.

4.7. “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхжуулах” зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.7.1. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид туршлага, мэдээллээ харилцан солилцох, судлах, технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэсэн олон талт сургалтыг зохион байгуулж, чадавхижуулах, мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэх;

4.7.2. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн мэргэшсэн ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах;

4.7.3. шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээг үзүүлэх;

4.7.4. хөдөө аж ахуйн чиглэлийн их, дээд сургуулиудад эрчимжсэн аж ахуйн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, тусгай хөтөлбөрөөр богино хугацааны сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах;

4.7.5. эрчимжсэн мал аж ахуйн ололт, амжилтыг урамшуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

4.7.6. эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, үйл ажиллагааны чиглэлээр төрөлжсөн, шатлал ахисан зэрэг дэв олгох, ажлын үр дүнгээр урамшуулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.



Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

5.1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг дараахь 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

5.1.1. I үе шат: 2019-2020 он

5.1.2. II үе шат: 2021-2023 он

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

6.1. Эрчимжсэн мал аж ахуйн зохион байгуулалтыг төрөлжүүлж, кластер, ложистикийн сүлжээг бий болгоно.

6.2. Импортоор авч байгаа малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 15-100 хүртэл хувиар багасгаж, 4 хүртэлх нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг тэглэж, гадагш урсах валютын урсгалыг бууруулна.

6.3. Гойд ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлж, төвлөрсөн хүн амын хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн балны дотоодын үйлдвэрлэл, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.4. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлээр дамжуулан боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулж, хүнсний аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулдаг болно.

6.5. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн техникийн шинэчлэлийг 50 хүртэл хувьд хүргэнэ.

6.6. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эдийн засгийн үр өгөөж, орлогыг нэмэгдүүлнэ.

6.7. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлж, хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах системд шилжүүлж, чадавхжуулна.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:



№	Шалгуур үзүүлэлт	суурь түвшин	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1.	Нийт мал сүрэг дэх өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувь	1.8	2.0	2.5	3.0	3.5	4.0
2.	Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын үнийн өөрчлөлт (сая ам.доллар)	140.8	129.6	119.2	109.7	100.9	92.8
3.	Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн тооны өөрчлөлт (мян.толгой)	61.0	70.2	82.4	98.4	117.4	140.3
4.	Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ (мян.литр)	134.2	161.5	222.5	295.2	375.7	491.1
5.	Нэг үнээнээс жилд авах сүүний хэмжээ (литр)	2200	2300	2700	3000	3200	3500
6.	Импортын шингэн сүүний бууралт (мян.тонн)	4.6	4.4	3.5	2.0	0	0
7.	Импортын хуурай сүүний бууралт (мян.тонн)	25.5	24.3	22.9	21.0	18.8	17.9
8.	Махны чиглэлийн үхрийн тооны өөрчлөлт (мян.толгой)	15.0	17.2	19.8	22.8	26.2	30.1
9.	Гахайн тооны өөрчлөлт (мян.толгой)	35.7	36.0	37.0	37.5	39.0	40.0
10.	Гахайн мах, өөх үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)	34.4	34.5	34.7	34.8	34.9	35.0
11.	Гахайн мах, өөхний импортын хэмжээний бууралт (тонн)	4.4	4.3	4.1	4.0	3.9	3.8
12.	Өндөг үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт (сая. ширхэг)	119.2	130.0	155.0	174.0	192.0	210.0
13.	Өндөгний импортын бууралт (сая.ширхэг)	83.9	69.0	48.0	30.0	15.0	0
14.	Зөгийн бүлийн тооны өсөлт (мянга)	8.1	10.6	13.5	16.7	20.5	24.0
15.	Зөгийн бал үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт (тонн)	113.4	210.0	255.0	300.0	330.0	375.0
16.	Зөгийн балны импортын бууралт (тонн)	216.6	191.0	160.5	120.0	80.6	51.6
17.	Экспортлолсон зөгийн балны хэмжээ (хувь)	1.0	2.0	4.0	6.0	8.0	10.0
18.	Тэжээлийн ургамал тариалсан талбайн өсөлт (мянган га)	29.9	40.0	55.0	70.0	80.0	100.0
19.	Хүчит тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)	110.0	120.0	135.0	150.0	165.0	185.0
20.	Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлсэн малын тоо (мянган толгой)	2.5	5.0	6.5	11.0	15.0	18.0
21.	Туршлага судалсан, сургалтад хамрагдсан эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо	50.0	200.0	350.0	500.0	650.0	800.0



Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

- 8.1.1. иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт;
- 8.1.2. улсын болон орон нутгийн төсөв;
- 8.1.3. гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж;
- 8.1.4. бусад эх үүсвэр;

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,
үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцийн нэгж холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулж, тайланг Засгийн газарт танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 1

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Ө.ЭНХТҮВШИН

ГАМШГИЙН ХОХИРОЛ, ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ (цаашид хохирол, хэрэгцээний үнэлгээ гэх) хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Гамшгийн хохирлыг гамшгийн улмаас учирсан шууд болон шууд бус бодит хохирлын нийлбэрээр илэрхийлнэ. Гамшгийн шууд бодит хохирол гэж хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин гамшигт өртсөний улмаас учирсан хохирлыг, шууд бус бодит хохирол гэж гамшгийн улмаас нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд доголдол гарснаас үүссэн хохирол болон гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээний зардлыг тус тус ойлгоно.

1.3. Гамшгийн хэрэгцээнд гамшигт өртсөн иргэн, хуулийн этгээд, орон нутагт шаардлагатай тусламж, үйлчилгээ, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүү, техникийн мэдээлэл хамаарна.

1.4. Хохирол, хэрэгцээний үнэлгээний зорилго нь гамшгийн хор уршигт дүн шинжилгээ хийж учирсан хохирлыг тооцон, нэрвэгдсэн хүн амын хэрэгцээ, нөөцийн бэлэн байдал, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавх, яаралтай тусламж, хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээ, хойшлуулшгүй сэргээн босгох болон хөгжлийн төлөвлөгөөнд шаардлагатай энэ журмын 2.2-т заасан мэдээллийг тодорхойлоход оршино.

1.5. Хохирол, хэрэгцээний үнэлгээ нь гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг тооцох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх, хүмүүнлэгийн тусламжийг олгох, гамшгийн хохирлын мэдээллийн сан бүрдүүлэх үндэслэл болно.



Хоёр. Хохирол, хэрэгцээний үнэлгээний
үе шат, хамрах хүрээ

2.1. Хохирол, хэрэгцээний үнэлгээгээр дараахь мэдээллийг тодорхойлно:

2.1.1. гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, дэд бүтэц, хүрээлэн буй орчинд учирсан шууд бодит хохирол;

2.1.2. эрэн, хайх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардал;

2.1.3. гамшгийн улмаас нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд доголдол гарснаас үүссэн шууд бус бодит хохирол;

2.1.4. гамшигт нэрвэгдсэн хүн амын анхдагч хэрэгцээг хангахад шаардлагатай тусламж, үйлчилгээний мэдээлэл;

2.1.5. эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд шаардагдах хүч хэрэгсэл, зардлын тооцоо;

2.1.6. хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүү, техникийн мэдээлэл.

2.2. Хохирол, хэрэгцээний үнэлгээ нь шуурхай үнэлгээ, гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээ гэсэн 3 үе шаттай байна.

2.3. Гамшгийн төрөл, үүссэн нөхцөл байдлаас хамааран энэ журмын 2.2-т заасан хохирол, хэрэгцээний үнэлгээг заавал шат дараалан хийхийг шаардахгүй байж болно.

2.4. Шуурхай үнэлгээ хийх аргачлал, тайлангийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээ хийх аргачлал, тайлангийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.



Гурав. Шуурхай үнэлгээ

3.1. Шуурхай үнэлгээг гамшгийн голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлгийн болон гал түймэр унтраах удирдагч, шаардлагатай тохиолдолд тухайн шатны Засаг дарга эсхүл орон нутгийн гамшгаас хамгаалах албаны даргын томилсон ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.

3.2. Шуурхай үнэлгээгээр гамшгийн голомтод үүссэн нөхцөл байдал, хор уршгийг урьдчилан үнэлж, гамшигт нэрвэгдэгсдэд нэн шаардлагатай хэрэгцээг тодорхойлж, эрэн хайх, аврах ажиллагаанд дайчлах хүч хэрэгсэл, гамшгийн үеийн яаралтай тусламжийг зохион байгуулах шийдвэр гаргахад ашиглах, энэ журмын 2.1.1, 2.1.4, 2.1.5-д заасан мэдээллийг тодорхойлж гаргана.

3.3. Гамшгийн төрөл, үүссэн нөхцөл байдлаас хамаарч шуурхай үнэлгээг 48 цагийн дотор хийж гүйцэтгэнэ.

3.4. Энэ журмын 3.3-т заасан хугацаанд шуурхай үнэлгээг хийж, тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад, шаардлагатай тохиолдолд тухайн шатны онцгой комисст хүргүүлнэ.

Дөрөв. Гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ

4.1. Гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээг орон нутгийн төрийн захиргааны байгууллага эсхүл тухайн шатны онцгой комиссоос томилсон, холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, салбарын шинжээчээс бүрдсэн шуурхай бүлэг хийж гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд хүмүүнлэгийн болон даатгалын байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

4.2. Энэ үе шатны үнэлгээгээр гамшигт өртсөн хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагт учирсан шууд бодит хохирол, гамшигт нэрвэгдэгсдийн хэрэгцээг тодорхойлж, нөөцийг нэмэгдүүлэх, дайчлах, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах шийдвэр гаргахад шаардлагатай энэ журмын 3.2-т заасан мэдээллийг илүү нарийвчилж, 2.1.2, 2.1.3-т заасан мэдээллийг шинээр гаргана.

4.3. Энэ үе шатны үнэлгээг 30 хоногийн дотор гүйцэтгэж, тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад, шаардлагатай тохиолдолд дээд



шатны онцгой комисст хүргүүлнэ. Үнэлгээ хийх хугацааг энэ журмын 4.1-д заасан шуурхай бүлгийг томилохдоо нарийвчлан зааж болно.

4.4. Үнэлгээний тайланд үндэслэн гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардлагатай нөөцийг гаргах, дотоодын болон гадаадын хүмүүнлэгийн тусламжийг авах саналаа Улсын онцгой комисс Засгийн газарт гаргана.

Тав. Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээ

5.1. Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээг тухайн орон нутгийн Засаг дарга эсхүл холбогдох салбарын яамнаас томилсон ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ. Энэ үнэлгээнд холбогдох мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулж болно. Шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн баг гүйцэтгэж болно.

5.2. Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээгээр хор уршгийг арилгах, сэргээн босгох, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах, тухайн төв, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусгах шаардлагатай энэ журмын 4.2-т заасан мэдээллийг илүү нарийвчилж, 2.1.6-д заасан мэдээллийг боловсруулна.

5.3. Гамшгийн төрөл, үүссэн нөхцөл байдлаас хамааран энэ үе шатны үнэлгээг 2-12 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

5.4. Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээний тайланд тусгасан нийт бодит хохирлын мэдээллийг тухайн шатны онцгой байдлын байгууллагад, сэргээн босгоход шаардлагатай хэрэгцээний мэдээллийг тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллагын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан нэгжид хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2019 оны 3 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат /илтгэгч/, Д.Ганзориг, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн А.Ариунболд, Б.Мөнхтөр болон түүний өмгөөлөгч Б.Батбаяр нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Ундрах-Эрдэнэ, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн А.Ариунболд нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн 1, 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасны дагуу шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байдаг.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч шүүхийн шийдвэрт гомдол гаргаж байгаа нь нэг талаас Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасны дагуу шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх, нөгөө талаас шударга шүүхийг эрэлхийлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шүүхийн алдаа зөрчлийг хянуулах, өөрийн гэм бурууг эцэслэн тогтоолгохоор зорьж буй хэрэг юм.

Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад шүүгдэгч, түүний өмгөөлөгч шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж, ялыг хүндрүүлэх боломжтой байдлаар хуульчилсан нь шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гомдол гаргах эрх, өөрийгөө өмгөөлөх эрх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хязгаарлажээ. Өөрөөр хэлбэл давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан шүүгдэгчийн эрх зүйн байдлыг анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд зааснаас дордуулах, гомдол гаргагчийн ялыг хүндрүүлэх зохицуулалтыг хуульчилсан шүүгдэгч өөрийн ялыг хүндрүүлэхээс эмээж, шударга шүүхийг эрэлхийлэх зоригийг мохоож, дарамт, айдас бий болгож, шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг хянуулахаас татгалзах үр дагаврыг үүсгэж байна.

Иймд шүүгдэгч гомдол гаргасан байхад шүүх шүүгдэгчийн гомдлыг авч хэлэлцээд, шүүгдэгчийн ялыг хүндрүүлж болохоор заасан нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрх, өөрийгөө өмгөөлөх эрхийг хязгаарлаж байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг хэрэгжихгүйд хүргэж байна.

Шүүгдэгчийн өмгөөлөгч нь шүүгдэгчид хууль зүйн туслалцаа үзүүлж, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалан давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргахад давж заалдах, хяналтын шатны шүүх гомдол гаргасан өмгөөлөгчийн үйлчлүүлэгч буюу шүүгдэгчийн ялыг хүндрүүлж болохоор заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан хууль зүйн туслалцаа авах, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэх заалтыг зөрчигдөхөд хүргэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно." гэсэн хэсэг, мөн хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах." гэсэн хэсэг, мөн хуулийн 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах," гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү." гэсэн байна.

Хоёр. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Мөнхтөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж заасан ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь Монгол Улсын иргэний хувьд шүүхийн шийдвэрт давж заалдах, Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, журмыг тодорхойлон заасан байдаг. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно." гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг



өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасан нь хэргийн оролцогч нарын шударга шүүхээр шүүлгэх, давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хязгаарлаж байна.

Тухайлбал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчдын эрхийг хязгаарласан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, үндэслэл, журмыг ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй асуудлаар мөрдөн байцаах, прокурор, шүүхийн үйл ажиллагаатай холбогдуулан хэргийн оролцогч давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад шүүгдэгчийн ялыг хүндрүүлэн өөрчлөх боломжийг давж заалдах, хяналтын шатны шүүхэд олгосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчил юм. Жишээлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн асуудлаар шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг дээд шатны шүүхээс хянан үзээд, хэргийн бодит байдал, зөв бурууг хуульд зааснаар хянаж шударга шийдвэр гаргахын оронд шүүгдэгчид оногдуулсан ялыг шууд хүндрүүлж, дээрх хуулийн заалтуудыг хэргийн оролцогч нарыг гомдол гаргуулахгүй болгох арга болгон ашиглаж байна. Сүүлийн үед давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийн оролцогч нарын гомдлоор хэргийг шийдвэрлэхдээ ял шийтгэлийн асуудлыг шүүх хуралдаан дээр хэлэлцэгдээгүй байхад, прокурорын саналаас давсан ялыг тодорхой үндэслэлгүйгээр хүндрүүлэн нэмдэг боллоо.

Хэргийн оролцогч Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэн шүүхийн гаргасан хуулийн зөрчлийг засуулахаар дээд шатны шүүхэд хандсан байхад давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ялыг нь хүндрүүлж байгаа нь хүмүүнлэг, энэрэнгүй байх Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт чанарыг эс хэрэгссэн, хүний эрхийн ноцтой зөрчил юм.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.” гэж, 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах

эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.” гэж, мөн Пактын 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр шийтгэгдсэнээ болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.” гэж тус тус заасан үүргийг Монгол Улс хүлээсэн байтал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг давж заалдах гомдол гаргах эрхийг нь хязгаарлаж байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчиж байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын холбогдох хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ..., өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ..., эрхтэй.” гэж заасныг зөрчсөн тухай дүгнэлт гаргана уу.” гэсэн байна.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн тайлбартаа:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан бөгөөд үүний хүрээнд холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн актаар иргэний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.” гэж хуульчилсан. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн зорилт болон ялын бодлого нь хэн нэгэн этгээд бусдын хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг зөрчсөн бол түүндээ тохирсон хариуцлагыг зайлшгүй хүлээх үзэл санаа, үр дагавартай байдаг.

Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэж байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь ямар нэг байдлаар нөлөөнд автаж, шүүгдэгчид түүний үйлдсэн гэмт хэрэг, гэм буруугийн хэлбэрт нийцээгүй буюу гэмт хэрэгт тухайн зүйлчлэлээр оногдуулж болох ялын төрлөөс хамгийн хөнгөнийг сонгох боломжтой бөгөөд энэ тохиолдолд Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчим алдагдахад хүрэх учраас уг сөрөг үр дагаврыг засах боломжийг дээд шатны шүүхэд олгох үүднээс дээрх заалтыг хуульчилсан.

Хэн нэгэн этгээд өөрийгөө гэм буруугүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтан эрх хэмжээгээ хэтрүүлэн ял оноосон, буруу зүйлчилсэн гэж үзэн дээд шатны шүүхэд хандан эрх, эрх чөлөөгөө хамгаалдаг. Ийм учраас хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг баталгаатай эдлүүлдэг. Түүнчлэн Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнөөр хохирогч бий болж байдаг бөгөөд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргагч иргэдийн дурдаад байгаа заалт нь хэн нэгэнд ял завших боломж олгохоос сэргийлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах давхар баталгаа болж байдаг.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Үндсэн хуульд шүүгдэгч шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг тусгаснаас гадна эрх, эрх чөлөө нь хөндөгдсөн хохирогч шүүхэд гомдол гаргах асуудал мөн ижил хамгаалагдсаныг дурдах нь зүйтэй.

2. Хууль тогтоогч өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хуульд заасан үндэслэл байвал хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, анхан шатны болон шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцааж хугацаа алддаг, оролцогчдод чирэгдэл үүсгэдэг, хэрэг замхрах нөхцөл байдлыг бий болгодог байсан зохицуулалтыг халж, зөвхөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас л хэргийг буцааж, шүүхийн бусад шатнаас хэргийг буцаадаггүй болгож хуульчилсантай холбоотойгоор давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр оногдуулсан ял хөнгөдсөн талаар дүгнэлтэд хүрсэн тохиолдолд ялыг хүндрүүлж болох эрх хэмжээг олгосон.

Энэхүү эрх хэмжээг олгосон бас нэг үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасантай нийцүүлэх, энэхүү үзэл баримтлалыг хэрэг хянан шийдвэрлэх хуульд бодитоор тусгаж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх явдал байсан.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын дээд шүүхэд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг хянах бүрэн эрхийг олгосон бөгөөд нэгэнт хянах эрх нь байгаа тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн /ял хөнгөдсөн/ шийдвэрийг зөвтгөх, буруу шийдвэрийг засах арга зам, тодорхой шийдвэр гаргах эрх нь зайлшгүй байх ёстой гэж үзсэний үндсэн дээр хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг дээрх байдлаар хуульчилсан.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар гомдол, эсэргүүцлийн дагуу эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс гарсан шийдвэрийг хяналтын шатны шүүх бүхэлд нь хянан үзсэний үндсэн дээр гэмт хэргийн зүйлчлэл болоод бусад бүх асуудал нь зөв, хуулийн дагуу байгаад гагцхүү оногдуулсан ял нь илтэд хөнгөдсөн талаарх дүгнэлтээ үндэслээд ялыг хүндрүүлж болохоор зохицуулсан.



Дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно." гэж, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ..., эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах." гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ..., эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй." гэсэн байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч иргэн А.Ариунболд, Б.Мөнхтөр нар нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэлэлцэж буй заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ..., эрхтэй.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн гэсэн мэдээллийн шаардлагаа дэмжиж, бусад шаардлагаас татгалзсан болно.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлан гаргахдаа 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно.", 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана." гээд 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана." гээд 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;"

гэсэн зохицуулалтыг тусгаж хэргийн оролцогчдын гаргасан гомдлын дагуу шүүхийн шийдвэрийг холбогдох шатны шүүх хянаад шүүхээс оногдуулсан ялыг хүндрүүлж болохоор хуульчилсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсэгт хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон тунхагласан бөгөөд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар хуульчлан тогтоосон. Мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах үндсэн эрхтэй болохыг бататган хуульчилсан юм.

Түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 5 дахь хэсэгт “Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр ... дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.” гэж бататган тогтоосон байдаг.

3. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд анхан шатны шүүх хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг анхан шатны журмаар, давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг талуудын гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр давж заалдах журмаар, Дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн магадлалтай холбогдуулан гаргасан эрх зүйн маргааныг талуудын гомдол, Улсын ерөнхий прокурор, эсхүл түүний эрх олгосон прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр хяналтын журмаар тус тус хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй байхаар хуульчилсан. Үүнээс үзэхэд анхан шатны шүүхийн шийдвэрээс шалтгаалж давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн ажиллагаа эхэлдэг. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд ханддаг бөгөөд гомдол, эсэргүүцлийн үндсэн дээр анхан шатны шүүх болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүснэ. Иймд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хүрээнд асуудлыг шүүгдэгчид ашигтайгаар буюу хэргийн бодит байдлыг тогтоон хүний эрхийг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд гаргасан үндэслэл бүхий гомдлыг шийдвэрлэх ёстой. Гэтэл



давж заалдах болон хяналтын шатны шүүх шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэргийг гомдлоор хянан хэлэлцэхэд гомдолд дурдаагүй асуудал, тухайлбал ялын асуудлыг хөндөж анхан шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлэх боломжийг бий болгох зэргээр шүүгдэгч (бусад шүүгдэгч)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлсэн байна.

Үүнээс үзэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх ... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно.”, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах.”, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах.” гэж хуульчлан анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд хандсанаар шүүгдэгчид илүү хүнд ял оноох, эрх зүйн байдлыг дордуулж болохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгын агуулгад нийцэхгүй байхаас гадна хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхийн шийдвэрийг давж заалдах иргэний үндсэн эрхийг хөндөж, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг

хөнгөрүүлж, хүндрүүлж болно” гэж, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасны “... хүндрүүлж ...”, “... эсхүл хүндрүүлж ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх ... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно.”, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;”, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх ...” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно.” гэж заасны “... хүндрүүлж ...” гэснийг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж заасны “... эсхүл хүндрүүлж ...” гэснийг, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт



өөрчлөлт оруулах,” гэж заасны “... эсхүл хүндрүүлж ...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Н.ЧИНБАТ
Д.ГАНЗОРИГ
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn
Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003